



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 11/403

Арвайхээр

Ж.Ханддэжиийг улсын асрамжийн
үйлчилгээнд хамруулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын "г", Нийгмийн халамжийн тухай хуулийн 19 дүгээр зүйл 19.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгийн Баян-Өндөр сумын хоёрдугаар багийн иргэн Жалбаагийн Ханддэжид (ЙГ70122005) нь 49 настай, төрсөн үр хүүхэдгүй, төрөлхийн хөгжлийн бэрхшээлтэй тул улсын асрамжийн үйлчилгээнд хамруулсугай.

2. Дээрх иргэнийг нийгмийн халамжийн асрамжийн үйлчилгээнд хамруулахад шаардагдах баримт бичгийг бүрдүүлэн Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газарт хүргүүлэх ажлыг зохион байгуулах, иргэнийг улсын асрамжид хүргүүлэхэд гарах зардлыг хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар (С.Ундрах)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Г.ГАНБОЛД



011100662

D:My Doc. Zahiramj. Zasag darga